

***“АМЬДРАЛЫН ИЛЧ” ХХК***

**УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГТ ОРШИХ БАЯНГИЙН  
ИХ АМ НЭРТЭЙ ГАЗАР БАЙРЛАХ “ДАЙРГАНЫ ОРД АШИГЛАХ” ТӨСЛИЙН  
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

## ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	4
1.1. Ерөнхий мэдээлэл .....	4
1.2. Төслийн байршил.....	5
1.3. Байгаль орчны өнөөгийн төлөв байдлын товч мэдээлэл .....	7
1.4. Уурхайн ашиглалтын систем, нөөц, ажиллах горим, хүчин чадал .....	9
1.5. Төслийн дэд бүтэц ба хангамж:.....	12
2. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ .....	13
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	16
3.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө .....	16
3.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	17
3.1.2. Нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө .....	18
3.1.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө .....	18
3.1.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө .....	19
3.1.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	19
3.1.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	20
3.1.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	21
3.1.8. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) .....	22
3.1.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	23
3.1.10. Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх .....	24

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Газарзүйн солбицол .....	5
Хүснэгт 2. Ордын геологийн нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт .....	9
Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим .....	9
Хүснэгт 5. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл .....	13
Хүснэгт 6. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээний нэгтгэл .....	15
Хүснэгт 7. БОМТ-г хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал .....	16
Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	17
Хүснэгт 9. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	18
Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	20
Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	21
Хүснэгт 13. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр .....	22
Хүснэгт 14. Удирдлага зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөө .....	23
Хүснэгт 15. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь .....	24

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төсөл хэрэгжих газрын байршил .....	5
Зураг 2. Агаар сансрын зураг .....	6
Зураг 3. Машин техник, тоног төхөөрөмжүүд .....	11

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 1-р хорооны нутагт орших “Баян ам” нэртэй 27.3 га талбай бүхий 15/R006 дугаартай тусгай зөвшөөрлийг Нийслэлийн Засаг даргын 2015 оны 04-р сарын 14-ний өдрийн шийдвэрээр 2911003058 дугаарын гэрчилгээтэй “Амьдралын илч” ХХК-д олгосон ба хайгуулын ажил явуулах батлагдсан төлөвлөгөөний дагуу тус компани эрэл-хайгуулын ажлыг 2017 онд гүйцэтгэжээ.

Тус хайгуулын ажлын үр дүнг боловсруулан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл /ЭБМЗ/-өөр хэлэлцүүлж тус зөвлөлийн 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн ХХ-12-14 тоот дүгнэлтийг үндэслэн АМГТГ-ын даргын 2017 оны 10-р сарын 16-ний өдрийн “н-90” тоот тушаалаар тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах барилгын чулууны бодитой (В) нөөцийг 7784.34 мян.тн-оор, боломжтой (С) нөөцийг 3206.7 мян.тн-оор, нийт бодитой болон боломжтой (В+С) нөөцийг 10991.02 мян.тн-оор шинжээчийн тооцоолсон хувилбараар хүлээн авсан байна. Улмаар 27.3 га талбай бүхий 18/M011 тоот тусгай зөвшөөрлийг 2018 оны 07-р сарын 25-ны өдөр өөрийн нэр дээр авсан байна.

ЭБМЗ-ийн нөөц хүлээн авсан дүгнэлтэнд үндэслэн Баян ам дайрганы ордыг ашиглах ТЭЗҮ боловсруулах ажлыг “Эрдэнэс инженеринг” ХХК-ий төслийн баг хийж гүйцэтгэсэн болно.

Ордын хуулах хөрсний зузаан дунджаар 2.35 м, олборлох ашигт малтмалын ашиглалтын уул-техникийн нөхцөлтэй уялдуулан 5 метрийн өндөртэй ашиглалтын мөргөцгөөр олборлох боломжтой юм. Тус дайрганы ордын талбай нь ил аргаар олборлоход хялбар орд юм. Ордын байрлах талбайн гадаргуу хэсгийн өндөрлөгийн оройгоор дайрганы түүхий эд болох цахиурлаг элсэн чулуу ил гарсан гарш байх ба ерөнхийдөө 0-4.0 м-ийн дундаж гүнтэй бутархай өгөршсөн хучаас хөрстэй байна. Ордын судлагдсан гүн 35 м, ашигт малтмалын дундаж зузаан 30 м байна.

Ил уурхайн жилийн хүчин чадлыг, уул техникийн нөхцөл, захиалагч байгууллагаас уг төслийг боловсруулах техникийн даалгавар зэргийг харгалзан жил тус бүр 150.0 мян.мЗ дайрга олборлохоор тооцлоо.

Уурхайн олборлох гүнийг геологийн нөөц бодогдсон 35 м хүртэл авсан ба хэрэглэгчдийг жилийн турш хэрэгцээт дайргаар хангаж байх асуудлыг тухайн үйлдвэрийн зохион байгуулалтын шийдлийн гол үндэс болгон авлаа.

Төсөлд үйлдвэрлэлийн бүтэц нь хөрс хуулалт, дайрга олборлолт, боловсруулалт, хэрэглэгчдэд өндөр чанарын буталж, шигшсэн дайргыг шууд хүргэхээр тусгасан байна

### 1.1.Ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: 

- “Баян ам” дайрганы ордыг ил аргаар ашиглах төсөл

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр: 

- “Амьдралын илч” ХХК
- Улсын бүртгэлийн дугаар: 2911003058

- Регистрийн дугаар: 4490886

Аж ахуй нэгжийн албан ёсны хаяг, утас

- Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 1-р хороо, Өвөршандын 2-4 тоот
- Утас: 976-96006580

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар

- 18/M011


Талбайн хэмжээ

- 27.30 га

## 1.2.Төслийн байршил

Төслийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн тийш 36 км, Налайх дүүргээс зүүн хойш 4 км зайд байрладаг. Засаг захиргааны хувьд Налайх дүүргийн 1-р хорооны нутагт харьяалагдана.

- Талбайн хэмжээ: 27.3 гектар
- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L-48–11



Зураг 1. Төсөл хэрэгжих газрын байршил

### Хүснэгт 1. Газарзүйн солбицол Өргөрөг

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	107	18	41,7	47	47	45,76
2	107	19	5,9	47	47	45,76
3	107	19	9	47	47	38
4	107	19	9	47	47	29,44



Зураг 2. Агаар сансрын зураг

### 1.3. Байгаль орчны өнөөгийн төлөв байдлын товч мэдээлэл

#### **Физик газарзүйн нөхцөл:**

Тус уурхай байрлах Налайхын хотгор нь газарзүйн хувьд Хэнтийн уулархаг нутагт хамаарах бөгөөд Хэнтийн гол ба салбар уулсын бэлийн бэсрэг уулс, ухаа толгодоор хүрээлэгдэнэ. Налайхын хотгор нь 200 км<sup>2</sup> талбайтай, өргөргийн дагуу бага зэрэг сунаж, урт нь 17-20 км, өргөн нь 10-12 км, умард талаараа өндөр бус уул толгодоор Туул голоор тусгаарлагдах ба уртрагийн чиглэлтэй хэд хэдэн богино хөндий хоолойгоор хэрчигдэнэ.

Хотгорын баруун хойт, баруун талаараа Баянзүрх, Богд уулын хаяа бэлийн уулс, өмнөд ба зүүн талаас нь Буурын даваа, Жанчивлангийн бэсрэг ухаа толгод хүрээлж үндсэндээ битүү хотос гэж болно. Хүрээлэх уулс нь ихээхэн хэрчигдэж бартаа ихтэйгээс гадна уулсын ар хажуу, гуу жалгаар ой мод, бут төгөл ургадаг. Хотгор гүдгэрийн үнэмлэхүй ба харьцах өндөр харилцан адилгүй. Толгодын үнэмлэхүй өндөр 1580-1750 м, хамгийн өндөр цэг нь дэлхийн усны хагалбар уулс болох Богдхан уул нь 2200 гаруй метр өндөрт өргөгдсөн.

Төслийн талбай нь район далайн түвшнээс дээш 1480-1550 метрийн үнэмлэхүй өндөрт байрласан толгодын бэл тэгш талыг хамарч тогтворжсон байна. Газрын гадаргын налуу буюу хэвгийн 11.50-22.70 (градус) байна.

#### **Уур амьсгал:**

Налайх дүүрэг эх газрын эрс тэс уур амьсгалтай, хур тунадасны хэмжээ бага температурын эрс хэлбэлзэлтэй, агаарын чийгшилт бага байдаг нь тус дүүргийн уур амьсгалын шинж юм. Өвлийн улирлын үргэлжлэх хугацаа 5-6 сар, цасан бүрхүүлийн дундаж зузаан 8 см. Хавартаа салхи ихтэй, агаар хуурай, хоногийн температурын хэлбэлзэл их, унасан цас эрт хайлж уурших тул голдуу шороон шуурга зонхилно.

Зуны улирал богино, халуун хур бороо багатай байдаг хөрсний улирлын хөлдөлт нь 10 сарын сүүлч 11 сарын эхээр эхлэн 4 сар хүртэл үргэлжилнэ. 5, 6-р сараас эхлэн улирлын хөлдөлт гэсэж эхэлдэг. 7 сард гэсэглэн үе нь гадаргаас 0.5 м хүртэл гүнд 8-р сард 0.5-1.5 м, 9-р сард 2-3 м хүртэл гүнд тус тус тохиолдоно.

Налайх дүүрэгтэй ойр орших Хүрэл тогоотын цаг уурын станцын хэмжилтээс үзэхэд агаарын температурын олон жилийн дундаж нь  $-1.8^{\circ}\text{C}$ , хамгийн хүйтэн үе болох 1-р сарын олон жилийн дундаж утга нь  $-27.4^{\circ}\text{C}$ , хамгийн бага үнэмлэхүй утга  $47.20^{\circ}\text{C}$  байдаг. Агаарын температур нь хамгийн өндөр утгандаа 7 сард дундаж нь  $+17.1^{\circ}\text{C}$ . Жилд унах хур тунадасны хэмжээ уулархаг газраа 207.3-369.8 мм-ийн хооронд хэлбэлзэх авч чухамдаа хотос хонхортоо үүнээс бага ажээ.

Жилд унах хур тунадасны 70-80% нь зуны улиралд тухайлбал 7,8-р сард буудаг. Хэвтээ гадаргын 1 м<sup>2</sup> талбайд үйлчлэх цасны жин 50 кг/см<sup>2</sup>. Агаарын чийгшилтийн сарын дундаж утга нь 50-70% хооронд хэлбэлзэх бөгөөд 60-65%-ийг дундаж утга гэж үзэж болох юм. Жилийн нийт өдрүүдийн 70% арчим нь салхитайд тооцогдоно. Салхины дундаж хурд өвөл 1.4 м/с, хавар 2.75 м/с, зун 2.92 м/с, намар 1.8 м/с. Үнэмлэхүй чийгшилтийн жилийн дундаж  $-4.5$  м/г, харьцангуй чийгшилтийн дундаж  $-62\%$ , VII сарын 13 цагийн харьцангуй чийгшил  $-59\%$ , жилийн тунадас 447 мм, дулаан улирлынх 41.5 мм, нэг хоногт орох 72 мм, цасны хамгийн зузаан 5 см байдаг.

### **Ус зүй:**

Төслийн талбай байрлах бүс нутаг нь Монгол орны гадаргын усны ангиллаар Хойд мөсөн далбайн ай сав, Туул голын сав газарт тус тус багтана.

Налайхын район усан сүлжээний хувьд муу, хотгорын нийт талбайн хэмжээнд ус багатай. Жижиг голуудын нэг болох Налайх гол Туул голд цутгадаг. Налайхын гол нь Баянбүрд уулын зүүн хормой дахь том биш гидролаххолит булгуудаас эх авч, хотгорын төв хэсгээр хойшоо чиглэн урсдаг. Голын голдрил нь 2-4 м өргөн, тунгалаг хүйтэн устай.

Налайх дүүрэг нь Туул голын дунд хэсгийн дээд талын хэсэгт оршдог. Энэ хэсэг баруун гараас Тэрэлж, зүүн гараас Элстэй, Налайхын голууд цутгадаг. Налайх голын сав газрын баруун доод хэсэгт Бүс нуур байдаг. Элстэй, Налайхын гол нь ус судлалын байнгын хяналт, ажиглалтад хамрагддаггүй учраас судалгааны өгөгдөл мэдээлэл хомс юм. Налайх ба Элстийн гол нь Налайхын хотгорт Налайхын нүүрсний их уурхайн дээгүүр урсдаг. Ус зүйн хувьд Налайх голын нэг онцлог нь нүүрсний ордын доорх нь талаас газарт шургаж 4 орчим км газар тасарч, дахин ил гарч 2 орчим км урсаад дахин хөрсөнд шургаж тасардаг.

Мөн энэ тасархайн доод хэсэгт Бүс нуур байдаг бөгөөд энэ нуур гүний тэжээлтэй нуур юм. Хэмжилтийн дүнгээр Налайх голын урсац гүнд шургахын өмнө  $0.057 \text{ м}^3/\text{с}$  байсан бол ил гарсны дараа  $0.032 \text{ м}^3/\text{с}$  болж буурснаас үзэхэд тэр алдагдсан 43% нь нуурын усыг газрын доогуур тэжээдэг байх магадлалтай юм. Яагаад гэвэл гол мөрний ус урсгалын дагуу нэмэгддэг зүй тогтолтой бөгөөд хэрэв урсац буурч байвал энэ хэсгийн газрын доорх усны төвшин голын усны төвшнөөс доогуур байгаагаас гол газрын доорх усаа тэжээх эсвэл ойролцоо орших нуурт цутгадаг. Бүс нуур нь хүхэрлэг шавартай тул нутгийн иргэд үе мөч, арьс, ядаргааны өвчнөө эмчлэхээр нуурын усанд орж, шаврыг нь эмчилгээнд хэрэглэдэг байсан байна. Нутгийн иргэдийн ярианаас үзвэл нуурын ус бохирдсон тул хүмүүс эмчилгээнд хэрэглэхээ больсон байна. Мөн энэ нуурын эргэн тойронд хужир, марзтай бэлчээр бий. Энэ бэлчээрт ойр хавийн малчид малаа хужирладаг.

### **Хүн ам, эдийн засаг, зам харилцаа:**

Налайх дүүрэг нь нийслэлийн Баянзүрх дүүрэг, Төв аймгийн Сэргэлэн, Эрдэнэ сумтай хиллэдэг. 68,7 мянган га нутагтай, 8992 өрхийн 32513 хүн амтай, Засаг захиргааны 7 хороо. 40568 малтай. Нийслэл хоттой авто болон төмөр замаар холбогдсон.

Төрийн төсөвт 28 байгууллагатай, Ерөнхий боловсролын сургуульд 6000 гаруй сурагч, Мэргэжлийн Сургалт Үйлдвэрийн Төвд 1200 гаруй хүүхэд, цэцэрлэгт 1126 хүүхэд тус тус суралцан байна. 120000, 45000 квт-ийн хос шугамаар Улаанбаатартай холбогдсон, эрчим хүчний хэрэглээг 10 дахин нэмэгдүүлэх чадалтай өртөөтэй.



## 1.4. Уурхайн ашиглалтын систем, нөөц, ажиллах горим, хүчин чадал

### 1.4.1. Ордын нөөц

“Баян ам” нэртэй дайрганы ордод явуулсан хайгуулын дүнгээр батлагдсан нөөцийг дараах хүснэгтэд харуулав. Түгээмэл тархацтай ашигт малтмал дайрганы олборлолтыг ил уурхайн хэлбэрээр 10 жилийн хугацаанд ашиглахаар тооцсон байна.

Хүснэгт 2. Ордын геологийн нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

д/д	Нөөцийн блокийн дугаар	Дайрганы огтлолын дундаж талбай, мян.м <sup>2</sup>	Зүсэлт хоорондын дундаж зай, м	Дайрганы нөөц, мян.м <sup>3</sup>	Дайрганы нөөц, мян.тн	Блокийн талбай мян.м <sup>2</sup>	Хөрсний зузаан. м	Хөрсний эзлэхүүн, мян.м <sup>3</sup>
1	В-I	6.32	223.5	1413.38	3816.14	43.94	2.28	100.2
2	В-II	7.5	195.93	1469.7	3968.2	39.29	2.45	96.27
Нийт В				2883.09	7784.34	83.24	2.36	196.46
3	С-1	2.73	212.22	578.41	1561.7	20.49	2.2	45.09
4	С-2	3.14	194.15	609.25	1644.99	19.07	2.5	47.67
Нийт С				1187.7	3206.69	39.56	2.35	92.76
Бүгд В+С				4070.75	10991.02	122.8	2.35	289.2

### 1.4.2. Үйлдвэрлэлийн хүчин чадал, ажиллах горим

Уухайг нийт 10 жил ашиглахаар ТЭЗҮ-д тусгасан ба IV сарын 01-нээс XI сарын 01 хүртэл 8 сарын хугацаанд үйл ажиллагаа явагдана. Олборлолт болон бутлалт, шигшилт тасралтгүй 6 сар үргэлжилнэ.

Ил уурхайн жилийн хүчин чадлыг, уул техникийн нөхцөл, захиалагч байгууллагаас уг төслийг боловсруулах техникийн даалгавар зэргийг харгалзан жил тус бүр 150.0 мян.м<sup>3</sup> дайрга олборлохоор тооцлоо.

Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим

д/д	Нэрс	Хэмжих нэгж	Жилд
1	Жилийн хуанлийн өдөр	хоног	214
2	Амралт, баяр ёслол	хоног	4
3	Цаг агаарын хүндрэл	хоног	16
4	Урсгал засвар хийгдэх	хоног	14
5	Уурхайн ажиллах ажлын өдөр	хоног	180
6	Уурхайн бэлтгэл ажил	хоног	10
7	Хөрс хуулах хоног	хоног	170
8	Олборлолт явуулах хоног	хоног	165
9	Хоногийн ээлжийн тоо	ээлж	2
10	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	8

#### Ажиллах хүч:

Захиргаа, ил уурхай, бутлан ангилах боловсруулах хэсэгт нийтдээ 44 хүн ажиллана.

### 1.4.3. Ашиглалтын системийн сонголт, тоног төхөөрөмж

Баян ам дайрганы ордын ашиглалтын гүн их биш, уул-геологийн нөхцөл энгийн тул авто тээвэртэй ашиглалтын системээр, ил аргаар ашиглах юм.

Олборлолтын ажлыг “экскаватор-автосамосвал”-ын хослолоор явуулна. Эхэлж дунджаар 2.65 м зузаантай шимт хөрс болон хөрсийг хуулж овоолго үүсгэсний дараа 5 м-н доголоор дайргыг экскаватор CAT-320С, HOWO автосамосвалын хослолоор тээвэрлэн

буталж, шигшиж барилгын материалын үйлдвэрлэлд нийлүүлэх стандартын шаардлагад нийцүүлэн хэрэглэгчдэд нийлүүлнэ.

Баян ам дайрганы ордын ашиглалтын үндсэн үйл ажиллагаа нь:

- Үржил шимт өнгөн хөрс хуулах
- Өрөмдлөг тэсэлгээний ажил хийх
- Хөрс хуулах
- Дайрга олборлох
- Олборлосон дайргыг бутлах төхөөрөмжийн ойролцоо тээвэрлэн буулгах
- Бутлагдсан дайргыг шигших
- Боловсруулагдсан бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх
- Хөрсний овоолго, тэгшлэлтийн ажил
- Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил.

Уурхайн бэлтгэл ажлаар дараахь ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

- Ажилчдын орон сууц барих, суурин байгуулах
- Тээврийн хэрэгсэл зорчих зам бэлтгэх
- Сэлбэг хэрэгсэл, шатахуун тос агуулах сав бэлтгэх, байрлуулах
- Уурхайн талбайг үерээс хамгаалах далан, шуудуу байгуулах
- Бутлах, шигших тоног төхөөрөмжийг угсрах, байрлуулах

Уурхайн цахилгаан болон усан хангамж, дэд бүтцийн бэлтгэл

Төслийн үйл ажиллагаанд доорх машин техник, тоног төхөөрөмжийг хэрэглэхээр ТЭЗҮ-д тусгасан байна.



Өрмийн машин JK358H



CAT-320C маркийн экскаватор



Howo маркийн автосамосвал



ZL-50 маркийн утгуурт ачигч



Shantui SD13 бульдозерын

Буталж, шигших ажлын технологид ашиглагдах тоног төхөөрөмжүүд



QV-924 маркийн доргилтот тэжээгч



OP-918 маркийн шигшүүр



MC-150 маркийн конусан бутлуур



2 дахь шатны бутлах төхөөрөмж



OP-918 маркийн шигшүүр



Туузан дамжуулагч

Зураг 3. Машин техник, тоног төхөөрөмжүүд

### **Өрөмдлөг тэсэлгээний ажил**

Уурхайд хөрс хуулах болон дайрга олборлох ажилд БНХАУ-д үйлдвэрлэсэн, JK358H маркийн цахилгаан өрмийн машин 1ш ашиглахаар сонгосон байна.

Уурхайн доголын өндөр 5м, налуугийн өнцөг 60-90<sup>0</sup> байхаар тооцсон бөгөөд 1м цооног тэслэхэд 18.1-22.2 м<sup>3</sup> уулын цул тэслэнэ. Жилд тэслэх уулын цулын нийт хэмжээ нь 150-260.4 мян.м<sup>3</sup> ба 12 удаагийн тэслэгээ хийгдэхээр тооцоолсон ба АНФО төрлийн тэсрэх бодис (Аммонийн нитрат ба дизель түлшний хольц), тэсрэх хэрэглээнд Нонель системийг хэрэглэнэ.

## **1.5.Төслийн дэд бүтэц ба хангамж:**

### **1.5.1. Уурхайн дэд бүтэц**

*Авто зам:* Уурхайн дотоод зам нь шилжилт хөдөлгөөн их хийгддэг тул шилжилттэй түр замаар хөрс болон дайрга тээвэрлэхээр тооцсон байна. Уурхайгаас дайрганы овоолго болон засвар механикийн цех хүрэх зам нь байнга ашиглагдах тул сайжруулсан, байнгын 2 зурвастай 12 м өргөн зам тавина.

*Засвар механикийн цех:* Уухайн техникийн үйлчилгээний дэд бүтэц нь ухааж ачих, зөөж тээвэрлэх, бутлах, шигших тоног төхөөрөмж болон бусад машин механизмуудад урсгал засвар, техникийн үйлчилгээ хийх, төрөл бүрийн материал, сэлбэг хэрэгсэл, шингэн түлш, тос хүлээн авах, хадгалах, түгээх зориулалт бүхий засварын жижиг газар байна.

*Хөрсний овоолго:* Тус дайрганы орд нь хөрс хуулалт харьцангуй багатай тул хөрсний овоолго бага байна.ил уурхайн баруун талд дунджаар 150-300 м зайд гадаад одоолго үүсгэнэ. Шимт хөрсний овоолгын эзлэхүүн 31.9мян.м<sup>3</sup> байна.

*Ил уурхай:* ил уурхайн нь 88479.56 м<sup>2</sup> талбайн хөрс хуулна.

### **1.5.2. Усан хангамж**

Уурхайн нь технологийн хэрэгцээнд ус ашиглахгүй. Уурхайд 35-44 хүн ажиллах ба хоногт 1.75-2.2 м<sup>2</sup>, жилд 180 хоногт 315-396 м<sup>3</sup> усыг унд ахуйн хэрэглээнд ашиглана. Унд ахуйн усыг зөөврөөр хангана.

### **1.5.3. Цахилгаан хангамж**

Уурхайн цахилгааны гол хэрэглэгчид нь өрмийн машин, 1 ба 2-р шатны бутлуур, шигшигч, конвейр, засварын цех, гэрэлтүүлэг болон бусад жижиг хэрэглэгчид байна. Эдгээр цахилгаан хэрэглэгчдийг уурхайгаас 1 км зайд өнгөрөх 35кВ-ын өндөр хүчдэлээс салгасан агаарын шугам татан эрчим хүчээр хангахаар тооцсон байна.

### ***Хөдөлмөр аюулгүй ажиллагаа:***

Тус уурхай нь Монгол Улсын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль, "Ашигт малтмалын ордыг ил аргаар олборлоход мордох аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм". болон "Ашигт малтмал газрын хэвлийн тухай хууль”,“Хөдөлмөрийн тухай хууль” тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, зааврын шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулна.

## 2. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Байгаль орчны нөлөөллийг магадлан жагсаах аргаар (checklist) тодорхойлж. Энэ арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм. Болзошгүй нөлөөлөлд хамрагдах байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт, байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны өөрчлөлт, нийгэм эдийн засаг, бусад гэсэн 6 үндсэн бүлэгт хувааж, магадлан жагсаах аргаар судлав. Нөлөөллийг “сөрөг”=(-), “эерэг”=(+), “нөлөөлөлгүй”=(0) гэсэн 3 бүлэглэлээр үнэлж эрчимжилтийг “бага”, “дунд”, “хүчтэй” гэсэн 3 зэргээр тогтоож, хэлбэр, хугацаа, чиглэлээр нь үнэлсэн болно.

Хүснэгт 4. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл

№	Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Хугацаа			Нөлөө		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино	Дунд	Урт	Буцах	Буцаалгүй	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
<i>Байгалийн экосистемийн өөрчлөлт</i>												
1	Газрын доорхи усны урсац, горим, чанар өөрчлөгдөх		0			0			0	0		
2	Уурхайн ухааш, хөрсний овоолго, зам болон барилга байгууламжаас ургамлын бүлгэмдэл, бүтцэд өөрчлөлт орох, талхлагдах	-				-			-			-
3	Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэлд орох, дарагдах	-				-			-			-
4	Хөрс хуулалт, дайрга олборлолтоос геологийн тогтоц өөрчлөгдөх	-				-			-		-	
5	Хүн, машин техникийн хөдөлгөөн, газар шорооны ажилтай холбоотойгоор ойр орчимд нутагладаг ан амьтдын амьдрах орон зай өөрчлөгдөх	-				-			-		-	
6	Бичил уур амьсгалын өөрчлөлт		-		-			-			-	
<i>Байгалийн нөөцийн ашиглалт</i>												
7	Газрын гадаргын нөөц баялаг	-				-			-		-	
8	Газрын доорхи усны нөөц		0			0			0	0		
9	Бэлчээрийн нөөц	-				-			-		-	
10	Эрчим хүчний нөөц			-		-			-	-		
<i>Байгаль орчны өөрчлөлт</i>												
11	Шатах тослох материалын хэрэглээ, хог хаягдал хадгалалт, зайлуулалттай холбоотойгоор газрын доорхи ус бохирдох		-		-				-		-	
12	Гадаргын усны бохирдолт	-				-			-		-	
13	Ил уурхай, хөрсний овоолго, зам зараг гадаргуугаас тоос босох, тээврийн хэрэгслийн хөдөлгүүр дэх шаталтаас үүсэх хорт хий зэргээс агаар бохирдох	-				-			-		-	
14	Шатах, тослох материалын хэрэглээ, хог хаягдал хадгалалт, зайлуулалттай холбоотой хөрс бохирдох	-				-			-		-	
15	Дуу чимээ шуугианы нөлөөлөл	-			-				-		-	
<i>Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл</i>												
16	Байгалийн төрх өөрчлөгдөх	-				-			-		-	
17	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	-				-			-		-	

№	Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Хугацаа			Нөлөө		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино	Дунд	Урт	Буцах	Буцалтгүй	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
18	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	-				-				-		
19	Түүх, соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	-				-			-	-		
<i>Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл</i>												
20	Улсад татвар төлөх, орлого нэмэгдэх	+				+			+		+	
21	Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+			+		+	
22	Ядуурлыг буруулахад дэмжлэг болох	+				+		+			+	
23	Ажлын байр нэмэгдэх	+				+		+			+	
24	Уурхайн хэрэгцээг дагаад орон нутгийн үйлчилгээний байгууллагын эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+				+			+		+	
25	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	-	-			-					-	
<i>Бусад</i>												
26	Ахуйн бохир усны цооног, бие засах газар, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, ялаа батгана, шавж үржих	-			-			-			-	
27	Байгалийн гамшиг, аюул осол	-			-				-		-	
<b>Нийт</b>		22	5	1	5	22	0	10	13	8	15	4

Тайлбар: Сөрөг нөлөөлөл байгааг: хүчтэй /-/, дунд /-/ , бага /-/  
Нөлөөлөл байхгүй /0/

Эерэг нөлөөлөл байгааг /+/ гэсэн тэмдэглэлээр үзүүлэв.

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөллийн 22 нь шууд, 5 нь шууд бус, 1 нь өөрөө зохицуулагдах байна. Нийт нөлөөллийн 8 нь бага эрчимтэй, 15-дунд эрчимтэй, 4-хүчтэй байна. Нийт нөлөөллийн 74.1% нь сөрөг, 18.5% нь эерэг, 7.4% нь нөлөөлөлгүй байна. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нийт нөлөөлөл нь шууд, дунд хугацааны, дунд зэргийн нөлөөлөл байна.

Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх нөлөөллийг тус бүрээр авч үзвэл уурхайн хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагаанаас хөрс болон ургамалд шууд, хүчтэй, дунд хугацааны турш буцалтгүй нөлөөлөх бол геологийн тогтоц өөрчлөгдөх, ойр орчимд нутагладаг ан амьтадын амьдрах орон зай өөрчлөгдөх нь дунд эрчимтэй сөрөг нөлөө үзүүлнэ.

Байгалийн нөөц ашиглалтын хувьд газрын нөөц болон бэлчээрийн нөөцөд дунд хугацаанд, дунд зэргийн эрчимтэй, шууд сөрөг нөлөөтэй. Харин уг төсөл нь ус ашиглахгүй тул газрын доорхи усны нөөцөд нөлөөгүй байна.

Төсөл хэрэгжих орчмын агаар, хөрсний чанарт шууд байдлаар, дунд хугацаанд, хамгийн их эрчимтэй буцах нөлөөлөл, газрын доорхи усны чанарт болон дуу шуугианы нөлөөлөл бага хугацаанд, буцах байдлаар дунд зэрэг нөлөөлнө.

Төслийн үйл ажиллагаанаас байгалийн төрх, түүх соёлын дурсгалт зүйлст дунд хугацаанд, шууд, сул эрчимтэй сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Төсөл хэрэгжих орон нутгийн эдийн засаг, нийгмийн асуудалд шууд байдлаар, дунд хугацаанд, буцалтгүйгээр дунд зэргийн эрчимтэй эерэг нөлөө үзүүлнэ.

Бусад нөлөөллийн тухайд хог хаягдлын цэг, ахуйн бохирын сан болон байгалийн гамшиг, гэнэтийн осол аваар зэргээс шууд болон шууд, богино хугацаанд, дунд зэргийн эрчимтэй сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

**Технологийн үе шаттай холбоотой байгаль орчны бүрдэл хэсгүүдэд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Дайрга олборлох технологийн ямар үе шатанд байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн аль хэсэгт илүү нөлөөлөхийг нарийвчлан тодруулах нь уг төслийн сөрөг нөлөөллийг бууруулахад чухал ач холбогдолтой. Иймээс байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон алт олборлох технологийн үе шатууд дахь нөлөөллийн эрчмийг үнэлэхдээ Леопольдын матрицын аргыг ашиглав.

Уурхайгаас дайрга олборлох технологийн үе шаттай холбогдсон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлохдоо экспертүүдийн нэгдсэн үнэлгээний дагуу нөлөөллийг 1- 10 (нөлөөллийн хамгийн бага утгыг 1, хамгийн их утгыг 10 гэж авна) баллын утгаар үнэлнэ. Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн тодорхой нэг үзүүлэлт болон дайрга олборлох, буталж нунтаглах технологийн тодорхой үе шатны хоорондох нөлөөллийн харилцан хамаарлыг авч үзэхдээ тэдгээрийн нөлөөллийн тоон утгыг илэрхийлсэн дөрвөлжин тус бүрийн зураасны дээд талд болзошгүй нөлөөллийн эрчмийг, доод талд нь нөлөөллийн чухал байдлын зэрэглэлийг тус тус тэмдэглэсэн болно.

Хүснэгт 5. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

Үйл ажиллагаа	Хөрс хуулалт хийх	Олборлолт явуулах	Хөрсний овоолго үүсэх	Нүх карьер үүсэх	Хүдэр тээвэрлэх	Буталж нунтаглах	Ухаж ачих	Ажиллагсдын тосгон байгуулах	Бүгд
Нөлөөлөлд өртөгч									
Агаар	4/5	5/5	3/4	3/3	4/4	5/5	3/3	2/2	29/31
Хөрс	7/8	7/6	4/4	8/7	4/4	3/3	4/4	5/4	42/40
Гадаргын болон газрын доорх ус	3/3	4/5	3/4	3/2	3/2	9/8	2/2	2/2	29/28
Ой, ургамал	7/6	8/6	5/5	6/5	4/3	3/3	3/3	2/2	38/34
Амьтан	1/1	2/2	1/1	1/1	2/2	1/1	1/1	1/1	10/10
Геологийн тогтоц өөрчлөгдөх, алтны нөөц хомсдох	8/7	10/10	7/6	8/9	3/3	4/4	2/2	2/2	44/43
Байгалийн үзэсгэлэнт тогтоц	2/2	5/4	3/3	5/4	1/1	2/2	2/2	1/1	21/19
Тусгай хамгаалалттай газар нутаг	1/1	1/1	1/1	1/1	1/1	1/1	1/1	1/1	8/8
Түүх, соёлын дурсгалт зүйлс	1/1	1/1	1/1	1/1	1/1	1/1	1/1	1/1	8/8
Нийт	34/33	43/40	28/29	35/33	23/21	29/28	19/19	17/16	229/221

### 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Зорилго:** Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

**Гол зорилтууд:**

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх; Налайх дүүргийн нутагт орших “Амьдралын илч” ХХК-ийн Баянгийн их ам нэртэй газар байрлах “Дайрганы орд ашиглах” төслийн 2023 оны БОМТ-г БОАЖ-ын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, мөн БОНХЯ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2014 оны А-117 тоот тушаалаар батлагдсан үнэлгээ хийх аргачлалыг баримтлан боловсруулсан болно.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн XII дугаар сард тухайн жилийн БОМТ- ний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

*Хүснэгт 6. БОМТ-г хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал*

№	Ажлын нэр	Зардал /мян.төг/
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	2 000.0
2	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	300.0
3	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	275.0
4	Нөхөн сэргээлтийн зардал	0.0
5	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний зардал	2100.0
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	400.0
<b>Нийт зардал</b>		<b>5075.0</b>

#### 3.1.Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

##### Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

БОННУ-ний тайланд төслийн цар хүрээнд бий болох сөрөг нөлөөллийн эрчим нь багаас дунд түвшинд хэлбэлзэх бөгөөд сүйрлийн хэмжээнд хүрэх ноцтой сөрөг нөлөө үзүүлэхгүй. Энэ нь төсөл хэрэгжүүлэх нутгийн байгаль, газарзүйн байршил, байгалийн нөөцийн нөхөн сэргэх чадавхтай холбоотой байх тул сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар арилгах боломжтой байна. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөхдөө ТЭЗҮ-д тусгагдаагүй, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзлээ.



### 3.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>НЭГ. АГААР ОРЧИН ЧАНАР</b>								
Агаар орчинд тоосжилт үүсэх	Дотоод тээврийн замаас тоосжилт үүсэлтийг бууруулахын тулд усалгаа хийх	Төслийн талбай	Өдөр	Үйл ажиллагааны зардал			2023 он	"Агаарын тухай", "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хууль, MNS 0017.2.3.16:1998
Тоосжилт	Тэсэлгээг тодорхой хуваарийн дагуу хийх, тэсэлгээ хийх үеийн салхины хурд, чиглэлийг харгалзан үзэх, хүчтэй салхитай өдөр тэсэлгээний ажил хийхгүй байх	Төслийн талбай	тогтмол	Үйл ажиллагааны зардал			2023 он	(суурьшлын хэсгүүдэд) MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.
						-		
<b>ХОЁР. ХӨРСӨН БҮРХЭВЧ</b>								
Газрын гадарга хөрс эвдрэл, элэгдэлд орох	Дотоод тээврийн 1км орчим замыг тэгшлэн, шороогоор дүүргэн сайжруулж сэргээн засах.	Уурхайн зам талбайд	км	1 000.0	1	1000.0	2023 он	"Газрын тухай" хуулийн 50–р зүйл 50.1.1 дэх заалт MNS 4597 : 2013 Авто замын тэмдэг. техникийн шаардлага "Газрын тухай" хуулийн 58.5 дэх заалт
	Зөвхөн тогтсон замаар тээврийн хэрэгслийг явуулах, бусад газарт хориглосон тэмдэг тэмдэглэгээ байршуулах, засварлах	Уурхайн зам талбайд	ш	100.0	1	100.0	2023 он	
	Шатах тослох материалыг ил задгай хөрсөнд шууд хаяхгүй байх, засвар үйлчилгээг зориулалтын цэгт хийдэг	Уурхайн талбай	тогтмол	Үйл ажиллагааны зардал			2023 он	

	байх							
								1 100.0
<b>ГУРАВ. УРГАМЛАН НӨМРӨГ, АМЬТНЫ АЙМАГ</b>								
Хөрсний овоолгод үе шаттайгаар нөхөн сэргээлт хийх буюу нэг болон олон наст ургамал тарих	Суулгац худалдан авах	Ажилчдын тосгон орчимд	ш	Улиас мод-50	300.0	2023 он	Ойн тухай хууль /2012 оны шинэчилсэн найруулга/ 2021.10.04 өдрийн №58 дугаар МУЕ-ийн зарилга “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн	
	Мод бут тарих, ургамалжуулах		удаа	Хөрс бэлдэх	500.0			
	Мониторинг хийх		удаа	-	100.0			
					900.0			
<b>Нийт</b>					<b>2 000.0</b>			

### 3.1.2. Нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө

2023 онд нөхөн сэргээлт хийхгүй болно.

### 3.1.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалал хийх аргачлалд зааснаар жижиг төслүүдийн хувьд дүйцүүлэн хамгааллын хамтарсан байдлаар хэрэгжүүлэх боломжтой бөгөөд гагцхүү нөлөөллийн хэмжээг тогтоох шаардлагатай юм. Иймээс тус компани дүйцүүлэн хамгаалал хийх арга хэмжээг төсөл хэрэгжих талбайн ойролцоох хэсэгт хариуцлагагүй уул уурхайгаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, биологийн олон янз байдалд эергээр нөлөөлөх байдлаар аймаг, сумын байгаль орчны албатай хамтран төлөвлөх боломжтой гэж үзэж байна.

#### Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Нөхөн сэргээлт	Уул уурхайгаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээх		4.43 га	2 100.0		2023 он	
<b>Нийт дүн</b>				-	<b>2 100.0</b>		

Амьдралын илч ХХК нь 2021 оны 09-р сарын 20-ны өдөр Нийслэлийн байгаль орчны газартай эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээх гэрээ байгуулсан. Үүний дагуу 2023 онд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэнэ. /Гэрээг хавсралтаар хавсаргав./

#### **3.1.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө**

Уурхайн сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллагыг зайлшгүй нүүлгэх шаардлагатай болсон тохиолдолд тэднийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулна. Ингэхдээ тэдэнд өгөх нөхөн олговрыг хэдийд өгөх, шинэ газарт нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг тэдний саналыг харгалзан хэдийд зохион байгуулахыг тодруулан тусгана. Энэхүү төслийн хувьд иргэд оршин суугчдад үзүүлэх хүчтэй сөрөг нөлөөлөл байхгүй байна.

Хэрэв цаашид нүүлгэн шилжүүлэлт нөхөн олговортой холбоотой асуудал гарвал газар болон бусад үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой өмчлөх, хуваарилах, бэлэглэх, шилжүүлэх үйл явцыг Монгол улсад дараах хууль тогтоомжуудаар зохицуулна. Үүнд:

1. Үндсэн хууль (1992);
2. Газрын тухай хууль (2002);
3. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2003);
4. Иргэний тухай хууль (2002) багтана.

#### **3.1.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах Монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх
- Төслийн талбайгаас түүх соёлын дурсгалт олдворуудыг археологийн судалгаагаар илрүүлсэн боловч олборлолтын үед газар дээр ямар нэг таних тэмдэггүй дурсгал илэрч болзошгүй тул төсөл хэрэгжүүлэх явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.
- Төслөөс шууд өртөж нөлөөлөгдөхөөргүй цэгүүдийг хамгаалах ажиллагаа, соёлын ба үнэт өв дурсгалтай газрыг хамгаалах төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулахдаа төв, орон нутгийн удирдах байгууллага, мэргэжилтнүүд, орон нутгийн олон нийтийн байгууллага, ШУА-ын Археологийн Хүрээлэн зэрэгтэй зөвлөлдөнө. Энэ төлөвлөгөө, хөтөлбөрийг төслийн бүтээн байгуулалт эхлэхээс өмнө төлөвлөж мөрдөнө.

### 3.1.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хэрэгжилтэд тавигдах шалгуур, мөрдөх стандартууд
<b>АХУЙН ХОГ ХАЯГДАЛ</b>								
Ахуйн хэрэглээний хог хаягдал	Энгийн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, эмх цэгцтэй хадгалах хогийн сав байршуулах.	Төслийн талбайд	ширхэг	200.0	2.0	200.0	2023 он	Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга 2017.05.12/
Буруу хадгалсан хог хаягдал түүний эх үүсвэрээс үнэрийн бохирдол гарах	Үйлдвэрийн ажилчдад зориулан хог хаягдлын ангилан ялгаж хаях талаар заавар зөвлөмж бүхий зурагт хуудас, зөвлөмжүүдийг байршуулах	Төслийн талбайд	ширхэг	Дотоод зардал			2023 он	Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага БОАЖ-ын сайдын А/443 тушаал
	Ажилчдыг хог хаягдлыг ангилан ялгаж хаях дадал суулгах	Үйлдвэрийн ажилчдад	удаа				2023 он	
Нийт				200.0				
<b>АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ</b>								
Аюултай хог хаягдал ил задгай хаях	Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж эмх цэгцтэй хадгалах цэг байгуулах	Төслийн талбайд	тогтмол	200.0	1	200.0	2023 он	ЗГ-ын 2018 оны 116-р тогтоолын “Аюултай хог хаягдлын жагсаалт” журам
	Үйл ажиллагаанаас гарсан ажилласан тос тосолгоо, шатах тослох материалыг тусгайлан битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан хадгалах, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх.	Төслөөс үүсэх аюултай хог хаягдал	удаа	Дотоод зардал		2023 он		
Нийт						400.0		

### 3.1.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал / мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Осол эрсдэл үүсэх	Ажил эхлэхийн өмнө ажилтан бүрт хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгсний дараа ажил эхлүүлэх	Уурхайн талбайд	Үйл ажиллагааны зардал		2023 он	Гамшгаас хамгаалах тухай хууль
	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Уурхайн талбайн орчимд	200.0	200.0	2023 он	
	Тэсэлгээний ажлыг мэргэжлийн үнэмлэхтэй тэсэлгээчин хийх буюу мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх	Уурхайн талбайд	Үйл ажиллагааны зардал		2023 он	
Галын аюулгүй байдал	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм журам боловсруулж мөрдөж ажиллах	Уурхайн талбайн орчимд			2023 он	Галын аюулгүй байдлын тухай хууль
	Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байршуулж байнгын бэлэн байлгах, галын аюул гарах болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах, нөхөж тавих	Уурхайн талбайн орчимд	100.0	100.0	2023 он	
Химийн бодисын эрсдэл	Химийн бодистой харьцаж буй жолооч, ажилчдыг мэргэжлийн сургалтанд хамруулах, химийн бодисын хор аюулын мэдээлэл, бодистой ажиллах аюулгүй ажиллагааны талаар мэдлэгтэй болгох	Уурхайн талбайн орчимд	Үйл ажиллагааны зардал		2023 он	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
	Ажилчдыг химийн бодистой ажиллах хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр бүрэн хангах, хэрэглэж хэвшүүлэх	Бүх ажилчдад	Үйл ажиллагааны зардал		2023 он	
<b>Нийт</b>			<b>300.0 мян.төг</b>			

### 3.1.8. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)

Хүснэгт 11. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчны бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналт шинжилгээ явуулах төрөл, хэлбэр	Хугацаа, давтамж	Сорьц авах цэгийн байршил	Зарцуулагд ах төсөв /мян.төг/	Нийт төсөв	Хяналт шинжилгээ явуулах арга, аргачлал
<b>Агаар орчин</b>	Агаарын бохирдуулагч бодис (SO <sub>x</sub> , NO <sub>x</sub> , TSP гэх мэт)	Уурхайн агаарын бохирдол үүсгэж буй цэгт	Төсөл хэрэгжих хугацаанд 1 удаа	Бутлах хэсэг Ил уурхай Овоолго Автозам	50.0	150.0	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2008 MNS 4585:2016
<b>Усан орчин</b>	Химийн ерөнхий шинжилгээ	Унд ахуйн ус	Төсөл хэрэгжих хугацаанд 1 удаа	Ундны усны худаг-1	25.0	25.0	Ундны усны эрүүл ахуй, чанарын хяналт MNS 0900:2018 Ус хангамжийн эх үүсвэр сонгоход тавигдах шаардлага MNS 0899:1992
<b>Хөрсөн бүрхэвч</b>	Ерөнхий химийн шинжилгээ болон хүнд элемент (Cu, Cr, Pb, Cd, As, Zn)		Төсөл хэрэгжих хугацаанд 1 удаа	Тэсрэх бодисын бодисын агуулах, Дотоод тээврийн зам, Ил уурхай	25.0	75.0	Хөрсний чанар хөрс бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.MNS 5850:2019
	Хөрсний эрүүл ахуй	Бохирдолд өртөх магадлалтай газар	Төсөл хэрэгжих хугацаанд 1 удаа	Ажилчдын тосгон	25.0	25.0	Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS 3297:2019
<b>Орчны хяналт шинжилгээний нийт зардал</b>					<b>275.0 мян.төг</b>		

### 3.2.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Нийт зардал, сая төгрөг	2023 он				Хариуцсан албан түшаалтан	Тайлбар
		I улирал	II улирал	III улирал	IV улирал		
Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх (5 жилд 1 удаа).	Гэрээний үнийн дүнгээр			+		БО-ны мэргэжилтэн	Газрын тухай хуулийн 58.5
Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Тохиролцох			+		Үйл ажиллагааны менежер	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод төлөвлөлтөөр	+	+	+	+	Үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Байгаль хамгаалах талаар хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр БОАЖЯ –нд хүргэж баталгаажуулах. /Тухайн жилийн БОМТ/	Дотоод төлөвлөлтөөр				+	Үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ –нд хүргэж өгөх. /БОМТ-ний биелэлтийн тайлан/	Дотоод төлөвлөлтөөр				+	БО-ны мэргэжилтэн	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
БОНБУ үнэлгээний тухай хууль, Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Дотоод төлөвлөлтөөр			+		БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
<b>Нийт зардал мян. төг</b>		-					

### 3.2.9. Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх

Хүснэгт 13. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
Амьдралын илч ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн Улаанбаатар хотын Налайх дүүргийн иргэд, багийн дарга, сумын байгаль хамгаалагч	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээ хийсэн талаар (ppt) танилцуулга хийх	2023 онд төслийн үйл ажиллагаанаас үүссэн нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар болон хяналт мониторинг хийсэн тухай, орон нутагтай хамтран ажилласан тухай	Жил бүрийн 11 сард	150.0	Байгууллагын БО-ны мэргэжилтэн	БОАЖЯ
<b>Нийт зардал мян. төг</b>				<b>150.0</b>		



